Шууд Санхүүжилтийн Ерөнхий Хэлэлцээр – Мехлопат

Байршил:	Монгол Улс
Төслийн дугаар:	52279
Бизнесийн салбар:	Үйлдвэрлэл, Үйлчилгээ
Мэдэгдлийн төрөл:	Хувийн
Байгаль Орчны Ангилал:	B
Батлагдсан өдөр:	2020 оны Арван нэгдүгээр сарын 17
Төлөв байдал:	**Батлагдсан**
Англи хэл дээрх ТХББ-ийг нийтэд танилцуулсан огноо:	2020 оны 11-р сарын 17 *Мэдээлэлд нэвтрэх бодлогын III хэсгийн 2.6-д зөвшөөрөгдсөний дагуу ТХББ-ийг олон нийтэд мэдээлэх хугацааг Мэдээлэлд нэвтрэх удирдамжийн 1.4.4-ийн дагуу хойшлуулсан болно.*

Төслийн танилцуулга

Монгол Улсын уул уурхай болон эрчим хүчний салбарт хэрэглээний материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт болон инженерийн үйлчилгээ үзүүлэгч Мехлопат компанид 2 сая евро хүртэлх (эсхүл үүнтэй тэнцэх хэмжээний ам.доллар) дүн бүхий барьцаат зээлийг эргэлтийн хөрөнгийн зорилгоор олгоно.

Төслийн зорилго

Төслийн зорилго нь Ковид-19 цар тахлын үед Мехлопат компанийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хүндрэлтэй цаг хугацааг даван гарахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Мөн, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтээс гадна, ЕСБХБ-аас Компанийн бизнес болон санхүүгийн стандартыг сайжруулах зөвлөх үйлчилгээг үзүүлэх болно.

Шилжилтийн Нөлөөлөл

Шилжилтийн нөлөөллийн дүн: 60

Төсөл нь гол зорилтуудын хүрээнд Компанийг дараах чиглэлээр дэмжинэ: Өрсөлдөх чадвар мөн Хүндрэлийг даван туулах.

Харилцагчийн Мэдээлэл

Мехлопат ХХК

Мехлопат компани нь уул уурхай болон эрчим хүчний салбарт хэрэглээний бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, тоног төхөөрөмж болон инженерийн үйлчилгээний үзүүлэх чиглэлээр 2002 онд байгуулагдсан. Мехлопат компани нь Монгол Улсын уул уурхайн тэргүүлэгч төслүүдтэй урт хугацааны тогтвортой харилцааг тогтоохын зэрэгцээ дэлхийн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг хамарсан нийлүүлэлтийн сүлжээг бий болгож чадсан.

Тус компанийг Монгол Улсын иргэн Ноён Баатарсүрэнгийн Гантулга эзэмшдэг.

ЕСБХБ-ны Санхүүжилтийн Дүн

2,000,000.00 евро

Төслийн Нийт Өртөг

2,000,000.00 евро

Банкны оролцоо

ЕСБХБ-с олгож буй зээл нь Мехлопат компанид Ковид-19 цар тахлаас үүдсэн нөхцөл байдалд дасан зохицох мөн цар тахалтай холбоотой ачааллыг багасгахад тус болно. Түүнчлэн, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх дэмжлэгээс гадна, Банкнаас олгож буй зээл нь дотоодын зах зээлд санал болгодоггүй 24 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй юм. Банкнаас үзүүлж буй зөвлөх үйлчилгээ нь Компанид бизнесийг өндөр стандартыг нэвтрүүлэх боломжийг олгоно.

Байгаль орчин, Нийгэмд үзүүлэх Нөлөөллийн Хураангуй

Ангилал B (2019 БОНБ). Чулуун тулгуур (Рокболт) үйлдвэрлэх, импортлохтой холбоотой байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл нь тухайн салбарт түгээмэл байдаг ба үүнийг үйлдвэрлэлийн стандарт туршлагыг ашиглан бууруулах боломжтой. Судалгаа нь Компанийн бөглөсөн Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын дэлгэрэнгүй асуулга, мөн Компанийн талаарх олон нийтэд нээлттэй мэдээлэл зэрэг дээр суурилан хийгдсэн. Компанийн удирдлага нь үйл ажиллагаа болон гүйцэтгэлээс үүсэх Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын эрсдэлийг удирдах зохих чадвартай бөгөөд энэ нь Банк-ны Гүйцэтгэлийн шаардлагад нийцсэн байна. Энэ төсөлд Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө хийх шаардлагагүй.

Техникийн Хамтын Ажиллагаа (“ТХА”), Буцалтгүй тусламжийн Санхүүжилт

1) Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу санхүүгийн тайланд аудит хийх, Компанийн ажиллагсдад Нягтлан бодох бүртгэлийг сайжруулах сургалт зохион байгуулах. Төслийн нийт өртөг нь 13,684 евро ба үүнээс 4,354 еврог Компаниас төлсөн.

2) Хуулийн судалгаа. Техник, Хамтын ажиллагааны өртөг нь 10,000 евро хүрэх төлөвтэй байна.

Дээрх хоёр ТХА нь Европын Холбооны Азийн Хөрөнгө Оруулалтын Сангаас санхүүжигдэнэ.

Энэхүү төсөл нь ЕСБХБ-ны COVID-19 тахлын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд батлагдсан болно. Мэдээллийн санд нэвтрэх удирдамжийн 5-р хэсэгт заасны дагуу төслийн хэрэгжилтийг цаг алдалгүй явуулах зорилгоор ЕСБХБ-ны Ерөнхийлөгч нь ТХББ-г зарлах стандарт хуваариас өөрөөр зарлах зөвшөөрөл олгосон болно. Банкны COVID-19 тахлын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон хуваарийн өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүйг Банкны веб хуудаснаас харна уу.

Компанитай холбоо барих

Ноён Баатарсүрэнгийн Гантулга

gantulga@mekhlopat.mn
+976 7500 1166
www.mekhlopat.mn
Монгол Улс, Улаанбаатар хот, Энхтайвны Өргөн чөлөө, 2-р хороо, Баянгол дүүрэг, Гранд Плаза комплекс, 801 тоот.

Төслийн Хураангуйг шинэчилсэн огноо

2020 оны 12-р сарын 8

Холбогдох баримт

Төслийн ерөнхий бүтэц

- Ерөнхий хэлэлцээр: Шууд Санхүүжилт ЖДҮ
  Нийтлэгдсэн: 13.03.2015

Шилжилтийг ойлгох нь

ЕСБХБ-с шилжилтийн нөлөөллийг хэмжих хандлагын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авах боломжтой.

Бизнесийн Боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-ны бизнесийн боломжууд (худалдах авах ажиллагаатай уялдаагүй) –н талаарх мэдээллийг доорх хаягаар авна уу:

Утас: +44 20 7338 7168
Цахим шуудан: projectenquiries@ebrd.com
Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг ЕСБХБ-ны Худалдан авалт вэб хуудаснаас авна уу:

Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий Лавлагаа

Тусгай лавлагааг ЕСБХБ-ны ерөнхий лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Байгаль Орчин, Нийгмийн Бодлого (БОНБ)

БОНБ болон үүнтэй уялдах Гүйцэтгэлийн Шаардлагууд (PRs) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг дэмжих ажлын хүрээнд тодорхойлогдсон болно. БОНБ болон Гүйцэтгэлийн Шаардлагууд нь харилцагчдад олон нийтийн мэдээллийн талаарх дотоод хууль тогтоомж, холбогдох шаардлагыг дагаж мөрдөх заалтуудыг оруулсан ба оролцогч талуудын санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, ялангуяа харилцагч болон төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны талаар гомдол, санал гаргах тогтолцоог бий болгоход оршино. Төслийн байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэлүүд, нөлөөллүүд нь байгаль болон төслийн цар хүрээтэй адил тэнцүү байх, ЕСБХБ нь өөрийн харилцагчдаас хэрэгжүүлж буй төслүүдээс үүдэн гарах эрсдэл, нөлөөллийн талаарх шаардлагатай мэдээллийг ил тод байлгахыг эсхүл оролцогч талуудтай сайтар зөвлөлдөх, санал хүсэлтийг хүлээн авч хариу мэдээллийг цаг тухайд өгч байх шаардлагуудыг тус тус тавьдаг.

ЕСБХБ-ны үйл ажиллагааны туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг БОНБ-д тусгасан болно.

Шударга байдал болон Хянан Нийцүүлэлт

ЕСБХБ-ны Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Газар (ХНЭГ) нь сайн засаглалыг дэмжиж, Банкны бүхий л үйл ажиллагаанд олон улсын шилдэг туршлагын дагуу шударга байдлын хамгийн өндөр стандартыг мөрдөж ажиллахыг баталгаажуулан ажилладаг болно. Шударга байдлын судалгааны ажил нь Банкны бүх харилцагчдад хийгддэг ба энэ нь аливаа төсөл Банкнаас хүлээн зөвшөөрөхгүй шударга бус байдал эсхүл нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлээс сэргийлэх зорилготой. Төслийн үнэлгээний шатанд асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх нь Банкны төслүүдийн шударга байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга юм. ХНЭГ нь эдгээр урьдчилан сэргийлэх ажилд голлох үүрэг гүйцэтгэн ажилладаг бөгөөд,

мөн төсөлд хөрөнгө оруулсны дараах шатанд шударга байдал хангагдаж буй эсэхэд хяналт тавин ажиллахад тусалдаг.

ХНЭГ нь мөн ЕСБХБ-с санхүүжсэн төслүүдэд залилан, авилгал, хууль зөрчсөн үйлдэл гарсан эсэхийг шалгах, мөрдөх үүрэг хүлээдэг. Банкны дотоод ажилтан эсхүл гадна байгууллагын хүн залилан эсхүл авилгын талаар сэжиглэж байвал Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Газарт бичгээр тайлан эсхүл compliance@ebrd.com хаягт цахим шуудан илгээн мэдээлэх эрхтэй. Үүнтэй холбоотой бүхий л мэдээллийг ХНЭГ хянан ажиллана. Бүх тайланд, үүнд нэрээ нууцалсан мэдээллүүдийг ч мөн ХНЭГ хянан ажиллана. Тайланг Банк эсхүл Банкны үйл ажиллагаа явуулж буй улс орнуудын аль ч хэлээр мэдээлэх боломжтой. Тайлагнасан мэдээлэл нь үнэн бодит байх шаардлагатай.

Мэдээллийн Бодлогод Нэвтрэх (МБН)

МБН нь 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсноос хойш стратеги, бодлого, үйл ажиллагааны талаарх ойлголтыг бий болгохын тулд ЕСБХБ нь мэдээллийг хэрхэн ил тод болгох, харилцагч талуудтай энэ талаар зөвлөлдөх зарчмыг тодорхойлдог. Мэдээллийн Бодлогод Нэвтрэх хуудаст хандан ЕСБХБ-ны вэтбайт-д байх бүхий л мэдээлэлтэй танилцана уу.

Тусгай лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Төслийн Хараат бус Хариуцлагын Тогтолцоо (ТХБХТ)

Хэрэв Харилцагч эсхүл Банк-тай Байгаль орчин, нийгэм, олон нийттэй холбоотой олон нийтэд мэдээлсэн мэдээлэлтэй холбоотой гарсан асуудлыг шийдвэрлэж чадахгүй бол (жиш: Харилцагчийн Төслийн төвшинд гаргадаг гомдлын механизм эсхүл Банкны удирдлагатай шууд холбогдон), хувь хүн эсхүл албан байгууллагууд нь ЕСБХБ-ны Төслийн Хараат бус Хариуцлагын Тогтолцоо (ТХБХТ)-р дамжуулан асуудлыг шийдвэрлүүлэхийг эрэлхийлэх боломжтой.

ТХБХТ нь Төсөлтэй холбоотой гарсан (эсхүл гарах магадлалтай) асуудлуудыг бусдаас хараат бус байдлаар хянан үздэг. Энэхүү тогтолцооны гол зорилго нь: Төслийн оролцогч талуудын байгаль орчин, олон нийттэй холбоотой олон нийтэд мэдээлсэн мэдээлэлтэй холбоотой үүссэн асуудлыг харилцан ярилцаж шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх; Банк нь Байгаль орчин, Нийгмийн бодлого-ны дагуу ажилласан эсэх эсхүл Төслийн Мэдээлэлийн Бодлогод Нэвтрэх-д холбогдох нөхцөлийн талаар; мөн хамааралтай үед эдгээр бодлого дагаж мөрдөгдөхгүй байгаа нөхцөлийг шийдвэрлэх тал дээр ажиллах, Банкийг ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх.

Төслийн Хараат бус Хариуцлагын Тогтолцоо вэбсайтад хандан Хүсэлтийг хэрхэн нууцлалтай цахим маягт –аар, мөн цахим шуудан, шуудан эсхүл утсаар дамжуулан илгээх боломжтой. ТХБХТ нь хэрхэн Хүсэлт хэсгээр дамжуулан асуудал илгээх, хэрхэн үүн дээр ажиллах талаар ярилцах, асуултад хариулахад бэлэн байх бөгөөд энэ нь Төслийн Хариуцлагын Бодлого мөн Заавар–ын дагуу хийгдэнэ. Хүсэлт гаргагчдын хувийн мэдээллийг хүсэлтийн дагуу нууцлан ажиллана.